



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/150

Номгон

Г Хөдөө аж ахуйн салбарын хөтөлбөр, Г
төсөлд хөрөнгө зарцуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоолын 3, Засгийн газрын 2019 оны 156, 362, 418-р тогтоолууд, Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний 3,2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний үндэсний болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 9,000,000 (есөн сая) төгрөг, Хүнсний ногоо, Жимс жимсгэнэ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 9,000,000 (есөн сая) төгрөг, нийт 18,000,000 (арван найм)-н сая төгрөгийг Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

2. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Хөтөлбөр, төслийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /У.Балжинням/-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Б.Батсуурь/-д тус тус даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН

601020363



Аймгийн Засаг даргын 2015 оны 1 дугаар сарын 21-нд өдрийн 105 дугаар захирамжийн хавсралт

АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ, ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ НИЙГМИЙН ХЭМЖЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээ	Үр дүн	Төсөв /сая.төг/	Хариуцах байгууллага
1	Салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг Улаанбаатар хотноо томоохон үйлдвэрүүдээр туршлага судлах аялал зохион байгуулах	Орон нутгийн 40-с доошгүй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн мэдлэг мэдээлэл дээшилж, шинэ технологи нэвтэрч, үйлчилгээ сайжирна.	2,0	ХБТХОХ ХХААГ
2	Ингэний сүүний үйлдвэрлэлийн төсөлд шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах	Үйлдвэрлэлийн лого, бусад үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.	1,0	ХБТХОХ
3	Хуванцар савны хэрэглээг бууруулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн ур чадварын уралдаан зохион байгуулах	Хүнсний бус хуванцар савыг хэрэглээнээс халах, нөлөөллийн арга хэмжээ, зориулалтын хуванцар савны үзэсгэлэнг гаргах, тогоочдын ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулж орон нутгийн брэнд хоол үйлдвэрлэл шалгаруулна.	2,5	ХБТХОХ ХХААГ Аймгийн тогоочдын холбоо
4	Хөдөө аж ахуйн бэлтгэн нийлүүлэлтээр үйл ажиллагаа эрхлэгч хоршоог дэмжин Загвар хоршоо бий болгох, хоршоодыг дэмжих	Нэг загвар хоршоог бий болгох, хоршоодыг чадавхжуулсан байна.	1,5	ХБТХОХ ХХААГ
5	Гарааны бизнес эрхлэгчдийг бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих, шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах	Үзэсгэлэн худалдааны үеэр гарааны бизнес эрхлэгчдийг дэмжинэ.	2,0	ХБТХОХ Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци
Нийт төсөв дүн			9,0	

.....оОо.....

**“ХҮНСНИЙ НОГОО”, “ЖИМС ЖИМСГЭНЭ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

№	Зардлын нэр, төрөл	Хэмжих нэгж	Хугацаа	Шаардагдах зардал /сая. төг/
1	“Хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх тариаланчдын нэгдсэн сургалт”-ыг зохион байгуулж тэргүүн туршлага судлах талбайн сургалт хийх,	1 удаа	VIII/20	1,5
2	Жимс жимсгэнэ үндэсний хөтөлбөрийн хүрээнд жимс жимсгэний мод суулгацын үзэсгэлэн худалдаа, үр суулгац бэлтгэх арга зүйн сургалт	1 удаа	IV /19	1,5
3	Хүнсний ногооны нэр төрлийг нэмэгдүүлэх чанартай үрээр хангах	0,6 тн	VI /15	1,5
4	Хүнсний ногоо хөтөлбөрийн хүрээнд Баянхонгор аймагт газар тариалан эрхлэх систем ном гарын авлага материал хэвлүүлэх	1удаа	IX/19-22	2,0
5	“Өрхийн тариалан” болзолт уралдаан зохион байгуулж, шалгаруулах	1	XI/10	1,5
6	Тариалалт, ургац хураалтын талаарх ТВ нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэх	4	IV-XI	1,0
	Нийт			9,0

.....оОо.....